

НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2017 он)

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага, хариуцах эзэн
1	“Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил”-ийн хүрээнд зохион байгуулах ажилд иргэдийн оролцоог хангах	Иргэний танхим, хороодоор дамжуулан иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх	Жилдээ	ЗДТГ
		Төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний шийдвэрлэх хугацааг богинсгож, чирэгдэлийг багасгах	Жилдээ	ЗДТГ
2	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэдэд нээлттэйгээр байршуулж, биелэлтийг улирал бүр гарган олон нийтэд мэдээлэх	Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оны эхнээс төлөвлөж шаардагдах зардлыг тооцсон байх	2 дугаар сар	Байгууллагууд
		Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг тооцож цахим хуудсанд байршуулах	Жилдээ	Байгууллагууд
		Авлигын эсрэг хууль тогтоомжийн биелэлтийг хагас жил тутам нэгтгэн гаргаж, удирдлагад тайлагнах	Улирал бүр	ЗДТГ
3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлөөр хангах	Хууль тогтоомжийг сурталчлах өдөрлөг зохион байгуулах	8 дугаар сар	АТГ, ЗДТГ
		Авлигын эсрэг хууль, түүнтэй холбоотой журмаар гарын авлага боловсруулж, тараах	Жилдээ	ЗДТГ
		Авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн ач холбогдолын талаар таниулах, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргах талаар сургалт зохион байгуулах	1 дүгээр сар	ЗДТГ
		Удирдах албан тушаалтан, төрийн захиргааны албан хаагчдын дунд мэдлэг сорих тэмцээн зохион байгуулах	10 дугаар сар	ЗДТГ, байгууллагууд
4	Төрийн хяналтын үйл	Хяналт, шалгалтын төлөвлөгөө, дүн,	Жилдээ	ЗДТГ

	ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах	зөвлөмжийг цахим хуудсанд байршуулах Байгууллагын үйл ажиллагааг иргэд, үйлчлүүлэгчээр үнэлүүлэх	Жилдээ	ЗДТГ
5	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, цахим хуудас, мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Жилдээ	ЗДТГ
		Төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт, хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй байлган, мэдээлэл авах боломжийг хангах	Жилдээ	ЗДТГ
		Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл, журмыг олон нийтэд нээлттэй, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод байлгаж байгууллагын цахим хуудсанд байршуулах	Жилдээ	ЗДТГ
		Засаг даргын чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	Жилдээ	ЗДТГ
6	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу шилэн дансны стандартыг мөрдөж ажиллах	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд мэдээллэх	Жилдээ	ЗДТГ
		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах, цахим тендерийг хэрэгжүүлэх, зохион байгуулах	Жилдээ	Дүүргийн худалдан авах ажиллагааны алба
7	Ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэр гаргах явцад нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргуулж хэвших	Жилдээ	ЗДТГ
		Ёс зүйн дүрэм, ёс зүйн хорооны үйл	Жилдээ	

		ажиллагаа, ёс зүйн зөрчлийн мэдээ тайланг цахим хуудсаар мэдээлэх		ЗДТГ
8	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалтны судалгаа гарган холбогдох байгууллага, нэгжид мэдээлэх	II улирал	ЗДТГ
		Хуулиар болон Засгийн газраас зөвшөөрөгдсөн давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулах, давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргах	II улирал	ЗДТГ
		Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилгад нэгдэх, дэмжиж ажиллах, сурталчлах	Жилдээ	ЗДТГ
9	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх	Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл өгөх, ил тод, нээлттэй цахим суваг ажиллуулах, удирдлагад танилцуулан хэрэгжүүлэх боломжтой саналыг удирдлагын шийдвэрт тусгуулах	Жилдээ	ЗДТГ
		Төрийн захиргааны ажилтан, албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж тогтмол утас ажиллуулах	Жилдээ	ЗДТГ
10	Авлигатай тэмцэх газрын шийдвэрийн хэрэгжилт	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн бүртгэлийг хөтлөх, хэрэгжилтийг хангаж ажиллах	Жилдээ	ЗДТГ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС